

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.06.09**

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Meta Platforms компани Constellation Energy-тэй хиймэл оюуны үйл ажиллагааг дэмжих 20 жилийн гэрээ байгуулах
- Пүрэв гарагт Трамп болон Хятад улсын Ерөнхийлөгч Ши Жиньпин утсаар холбогдож, "хоёр орны хувьд маш эерэг үр дүнд хүрсэн" гэж Трамп өөрийн нийгмийн сүлжээндээ бичсэн
- Хөдөлмөрийн яамны мэдээлснээр 2025 оны тавдугаар сард 139,000 ажлын байр нэмэгдсэн бөгөөд 130,000 гэсэн төсөөлөлтэй харьцуулахад илүү өндөр үзүүлэлттэй гарсан.
- Хятад улсын хувьцааны зах зээл эдийн засгийн зарим сөрөг үзүүлэлтүүдийн дараа өссөн бөгөөд энэ нь засгийн газраас илүү их урамшуулал хэрэгжүүлэх магадлалтай гэж хүлээж буйг харуулж байна.
- Албан ёсны үйлдвэрлэлийн бус PMI, үйлчилгээ болон барилга байгууламжийг хамарсан индекс нь 50.3 болж, 50.4-тэй харьцуулахад буурсан байна.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>







## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.06.02-06.08

## АЖИЛ ЭРХЛЭЛТ САЙН БАЙНА

Америкийн гол хувьцаа индексүүд хоёр долоо хоног дараалан өсөлт үзүүлээ. Жижиг компанийн хувьцаа индекс өсөлтөөр тэргүүлж, Russell 2000 индекс 3.19%-иар өссөн бол Nasdaq Composite (2.18%) болон Dow Jones Industrial Average (1.17%) тус тус өсчээ. Салбарын түвшинд мэдээллийн технологийн хувьцаанууд илүү сайн үзүүлэлт гаргасан нь хиймэл оюун (AI)-тай холбоотой хувьцаануудад эерэг хандлага үүссэнтэй холбоотой. Meta Platforms компани Constellation Energy-тэй хиймэл оюуны үйл ажиллагааг дэмжих 20 жилийн гэрээ байгуулах тухай мэдээ нь тус салбар дахь хандлагыг сайжруулсан гэж үзэж байна.

Худалдааны хэлэлцээр нь долоо хоногийн гол сэдвүүдийн нэг хэвээр байсаар, АНУ ба Хятад улс хоорондын хурцадмал байдал Трампын сүүлийн үеийн нийгмийн сүлжээний тайлбаруудын дараа дахин нэмэгдсэн ч, Пүрэв гарагт Трамп болон Хятад улсын Ерөнхийлөгч Ши Жиньпин утсаар холбогдож, "хоёр орны хувьд маш эерэг үр дүнд хүрсэн" гэж Трамп өөрийн нийгмийн сүлжээндээ бичсэн бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдад асуудал шийдэгдэх итгэл найдвар төрүүлсэн байна.

Долоо хоногийн эдийн засгийн хуваарийн гол онцлох үйл явдал нь Баасан гарагийн ажлын байрны мэдээллийн тайлан байв. Хөдөлмөрийн зах зээл удааширч байгаа ч урьдчилсан таамгаас хамаагүй аажмаар буурч байгаа болохыг харуулсан. Хөдөлмөрийн яамны мэдээлснээр 2025 оны тавдугаар сард 139,000 ажлын байр нэмэгдсэн бөгөөд 130,000 гэсэн төсөөлөлтэй харьцуулахад илүү өндөр үзүүлэлттэй гарсан. Ажилгүйдлийн түвшин 4.2%-д тогтсон бөгөөд энэ нь 2024 оны 5-р сараас хойш 4.0%-4.2% хооронд хэлбэлзэж байна. Мэдээллийн дараа хувьцааны зах зээл өссөн байна. Томоохон эдийн засгийн тайлангуудын дараа гарсан ажлын байрны мэдээлэл нь хүлээлтээс илүү эерэг байлаа. Харин 5 сарын сүүлийн долоо хоногийн анх удаа ажилгүйдлийн тэтгэмж авсан тоо 8,000-аар нэмэгдэж 247,000 болсон нь 2023 оны 10-р сараас хойш хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Түүнчлэн, Хөдөлмөрийн яамний мэдээлснээр, 4-р сард ажлын байрны санал болон ажилтан авах үйл явц нэмэгдсэн ба энэ нь Трампын засгийн дэлхий даяар хэрэгжүүлсэн өргөн хүрээтэй тарифын хөтөлбөр эхний сарын түрш хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хүчтэй хэвээр байсныг харуулж байна.

Golomt\_Capital published on TradingView.com, Jun 08, 2025 22:44 UTC-4

NASDAQ 100 E-mini Futures - 1D - CME Q21,799.25 H21,820.75 L21,716.00 C21,734.25 -75.25 (-0.35%) -75.25 (-0.35%)



TradingView



## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.06.02 – 06.08

### ХЯТАДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ БУУСААР БАЙНА.

Эх газрын Хятад улсын хувьцааны зах зээл эдийн засгийн зарим сөрөг үзүүлэлтүүдийн дараа өссөн бөгөөд энэ нь засгийн газраас илүү их урамшуулал хэрэгжүүлэх магадлалтай гэж хүлээж буйг харуулж байна. Орон нутгийн CSI 300 индекс 0.88%-иар өсч, Шанхайн X composite индекс 1.13%-иар нэмэгдсэн байна, гэж FactSet мэдээллээ. Хонконгт Hang Seng индекс 2.16%-иар өссөн байна.

Хятад болон АНУ 5-р сарын 12-нд 90 хоногийн хугацаанд тарифуудыг бууруулах тохиролцоонд хүрсэн бөгөөд энэ нь удаан хугацааны гэрээ хийхээр цаашид хэлэлцээр хийх боломжийг олгосон байна. Албан ёсны үйлдвэрлэлийн бүс PMI, үйлчилгээ болон барилга байгууламжийг хамарсан индекс нь 50.3 болж, 50.4-тэй харьцуулахад буурсан байна. Caixin-ийн судалгаанд үйлдвэрлэлийн бууралт нь засгийн газар илүү их урамшуулал хэрэгжүүлж, АНУ-ын тарифын нэмэгдэлтэй тэмцэхийн тулд хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үзэл баримтлалыг өдөөж байна. Өнгөрсөн сарын түрш Хятадын төв банк хэд хэдэн хөнгөлөлтийн арга хэмжээ авч, үүнд долоо хоногийн урвуу репо хүү, үндсэн бодлогын хүү болон банкуудын нөөцийн шаардлагын хэмжээг бууруулсан байна.




















































Хятадын хэрэглэгчийн үнэ индекс 5-р сард дөрөв дэх сараа дараалан буурч, үйлдвэрлэлийн инфляци сүүлийн хоёр жилд хамгийн их уналттай гарчээ. Энэ нь Хятад улс АНУ-тай хийж буй хатуу худалдааны дайнтай тэмцсээр байгааг харуулж байна. CPI инфляци 5-р сард жилийн өмнөхөөс 0.1%-иар буурчээ. Сар суурьтай CPI 0.2%-иар буурсан. Энэ нь Хятадын дотоодын хэрэглээг хадгалахад засгийн газар сүүлийн хоёр жилд үргэлжлүүлэн зүтгэж байгааг илтгэнэ. Энэхүү инфляцийн мэдээлэл нь Лондон дахь АНУ-Хятадын худалдааны яриа хэлэлцээний өмнө гарсан. Худалдааны гэрээ байгуулах нь Хятадад чиглэсэн АНУ-ын тарифуудыг бууруулах ба 4-р сар хүртэл эдийн засагт учирсан гол дарамтыг хөнгөвчлөх боломжтой юм. Жишээ нь Хятадын үйлдвэрлэгчид гадаад зах зээлээс ирэх захиалгын бууралттай тулгарч байсан бөгөөд дотоодын эрэлт ч мөн саарсан. Харин энэ хэлэлцээр амжилттай болвол Хятадын үйлдвэрлэгч нарт эерэг нөлөө үзүүлнэ.

Golomt\_Capital published on TradingView.com, Jun 08, 2025 23:03 UTC-4

































Hang Seng Index Futures - 1M - HKEX: Q23,180 H24,092 L22,514 C24,052 +866 (+3.74%) +331 (+1.40%)



## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 02, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
 CPB	 CREDO	 DG	 CRWD	 DLTR	 MDB	 CEN	 AVGO	 GIII	
 SAIC	 ABIVX	 NIO	 HPE	 SPR	 PVH	 PCKR	 DOCU	 ABM	
		 SIG	 ASAN	 GEN	 FIVE	 XSG	 LULU	 FCEL	
		 OLL	 GWRE	 REV	 PL	 VSCO	 IOT	 MAND	
		 FERG	 HEQY	 THOR	 VINT	 LE	 RBRK	 MAND	
		 DON	 CBSE	 VBNK	 CHPT	 TTC	 WOOF	 MAND	
		 NESR	 MAMA	 WBS	 TLYS	 BFUF	 CURV	 MAND	
			 SPWH	 TTGT	 GEF	 BFBI	 TTAN	 MAND	
			 YEXT	 BARK	 DULUTH	 QUALEX	 ZUMZ	 MAND	
				 DESCARTES		 WATERDROP	 ZUMIEZ		
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>						© 2025 Earnings Whispers			

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 09, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
 GHM	 CASY	 UNFI	 GME	 CHWY	 ORCL	 LOVE	 ADBE	 MNY	
 MPAA	 CVOW	 ASO	 GTLB	 VSCO	 OXF	 HOOK	 RH		
	 LAKE	 SJM	 NAVY	 VRA		 ACM			
	 LMNR	 DBI	 SFX	 SAIL					
	 AI	 CNM	 PETS	 JILL					
	 SKIL								
	 CMTL								
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>						© 2025 Earnings Whispers			